



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 05

Мандалговь

Д.Цэнд-Аюушийг Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын Дэлгэрцогт сумын Газрын
даамлын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Дэлгэрцогт сумын Газрын даамлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Долзодням овогтой Цэнд-Аюуш 67.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Д.Цэнд-Аюушийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Дэлгэрцогт сумын газрын даамлын албан тушаалд
нэр дэвшүүлсэн Д.Цэнд-Аюушийн тухай дүгнэлт**

1. Д.Цэнд-Аюуш нь 1999 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 23 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2017-2021 онд Монгол Улсын их сургуулийг газар зохион байгуулагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Д.Цэнд-Аюушийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Дэлгэрцогт сумын газрын даамлын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ